



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.3.3, 6.4.3, 6.4.4, 6.4.6, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Барилга, хот байгуулалтын яамны Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2024 оны 02-00-07/0069/88 дугаар дүгнэлтээр тогтоогдсон, нийт 1,534,599,950.20 (нэг тэрбум таван зуун гучин дөрвөн сая таван зуун ерэн есөн мянга есөн зуун тавин төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 363,622,267.19 (гурван зуун жаран гурван сая зургаан зуун хорин хоёр мянга хоёр зуун жаран долоон төгрөг арван есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгө (барилга байгууламж)-ийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболор болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах, материалыг ялган тоолж, ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Акталсан барилга байгууламжийн доорх газар эзэмших эрхийг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээж, нөхөн сэргээх, зориулалтын дагуу ашиглах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000065

1-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн
20... дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСАНД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ (барилга байгууламж)-ИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк, байршил	Ашиглалтад орсон, дахин үнэлсэн он	Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1. ШШГЕГ-ын Сүлд спорт хороо							
1	Биеийн тамирын заал (Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсангийн аманд)	2012/2018	м2	750.39	403,291,500.00	123,383,055.84	279,908,444.16
2	Дулаан дамжуулах далд шугам	2012/2018	м	200	141,088,346.00	18,223,911.41	122,864,434.59
3	Хашаа (төмөр)	2012/2018	ш	1	5,827,200.00	3,156,400.00	2,670,800.00
	Дүн				550,207,046.00	144,763,367.25	405,443,678.75
2. 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлэг							
2	Спорт буудлагын тийр (Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсангийн аманд)	2008/2018	м2	230	984,392,904.20	218,858,899.94	765,534,004.26
	Нийт дүн				1,534,599,950.20 (нэг тэрбум таван зуун гучин дөрвөн сая таван зуун ерэн есөн мянга есөн зуун тавин төгрөг хорин мөнгө)	363,622,267.19 (гурван зуун жаран гурван сая зургаан зуун хорин хоёр мянга хоёр зуун жаран долоон төгрөг арван есөн мөнгө)	1,170,977,683.01 (нэг тэрбум нэг зуун далан сая есөн зуун далан долоон мянга зургаан зуун наян гурван төгрөг нэг мөнгө)